







**Логоны тайлбар:** “Бид байгаль эхээ хайрлан хамгаалах үйлсэд оролцох үүрэгтэй, энэ үүргээ биелүүлснээр аврал эрсэн байгалиа хамгаалж тогтвортой, амар амгалан амьдарна.” гэсэн утгатай.



**Тэргүүн туршлага 1.** Эко зөвлөл нь сард нэг удаа хуралддаг ба үйл ажиллагааны биелэлт хэр байгаа болон цаашдын ажлын чиглэлийг ярилцдаг. Мөн байгаль хамгааллын чиглэлийн сургалт сурталчилгааны ажлыг тогдмол зохион байгуулж үр дүнг хурлаараа хэлэлцдэг.

**Тэргүүн туршлага 2.** Тус сургууль өөрийн эзэмшил хүнсний ногооны туршилтын талбайтай ба жил бүр багш сурагчид хамтран ногоо тариалдаг бөгөөд намар сургуулийнхаа хэрэгцээг бүрэн хангаж үлдсэн ногоогоо сумынхаа нэн ядуу, хөдөлмөр эрхлэх чадваргүй иргэдэд тусламж болгож өгдөг.

**Тэргүүн туршлага 3.** Зэрэг сумын сургуулийн 2 дахь туршлагаар тус сургуулийн тэмдэглэлт ойг хэрхэн үр дүнтэй бүтээлчээр тэмдэглэдэг. Өөрөөр хэлбэл их бүтээн байгуулалтыг хэрхэн хийдэг гэдгийг бусад сургуулиудад үлгэр дууриалал болохуйц тэмдэглэсэн байгаа нь тус сургуулийн нэг туршлага болон орж байна. Ийм үр дүнтэй ажиллахын нууц нь үйл ажиллагаагаа нээлттэй ойлгомжтой хүн бүрийн сэтгэл зүрхний оролцоо юм.